



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН  
2025 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**



## АГУУЛГА

<b>НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	3
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	4
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	5
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	6
<b>ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b> .....	8
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	8
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	10
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...11	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	12
<b>ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	13
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	13
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	15
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	15
3.4 Зээлийн чанарын талаар.....	16
<b>ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	19
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	19
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	20
4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар.....	20
4.4 Санхүүгийн бус өр төлбөр.....	21
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	22
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	22
<b>ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА</b> .....	23
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	23
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	23
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	24
<b>ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b> .....	25
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	25

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025.04.30

Улаанбаатар хот

## НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 176 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 ХЗХ буюу 4.3 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 52.3 хувь буюу 92 ХЗХ орон нутагт, 47.7 хувь буюу 84 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо (хот, орон нутгаар)



Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 1 ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн бол 11 ХЗХ-ны 122 сонгуульт гишүүн (давхардсан тоогоор), 4 ХЗХ-ны гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2021	2022	2023	2024	2025.I
ХЗХ-ны тоо	209	196	191	178	176
Шинээр олгосон	-	7	3	4	1
Хүчингүй болгосон	40	20	8	17	3
Түдгэлзүүлсэн	12	4	10	4	1
Сэргээсэн	1	3	1	2	-
ТЗ-ийн хугацаа сунгасан	85	62	-*	-*	-*

\*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 6.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бол гишүүдийн тоо дунджаар 0.9 хувиар, тэр дундаа орон нутгийн гишүүдийн тоо 7.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: ХЗХ-дын тоо, гишүүдийн мэдээлэл (хот, орон нутаг)

	2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I	Дүрслэл
Нийт ХЗХ-дын тоо	249	205	191	184	176	■ ■ ■ ■ ■
Улаанбаатар	148	114	101	95	84	■ ■ ■ ■ ■
Орон нутаг	101	91	90	89	92	■ ■ ■ ■ ■
Нийт гишүүдийн тоо	75,002	74,966	69,962	73,293	77,557	■ ■ ■ ■ ■
Улаанбаатар	45,037	43,969	38,326	40,103	42,050	■ ■ ■ ■ ■
Орон нутаг	29,965	30,997	31,636	33,190	35,507	■ ■ ■ ■ ■


## 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 176 ХЗХ 61 салбар, 626 ажилтан, 77,557 гишүүн (77,216 иргэн, 341 хуулийн этгээд)-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод Багахангай дүүргээс бусад дүүрэгт 84 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 ХЗХ буюу 11.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд төвлөрөл хамгийн их байна.

Монгол Улсын 21 аймагт 92 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 ХЗХ буюу 3.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



### 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2025 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,264 буюу 5.8 хувиар өсөж 77,557-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 53.8 хувь буюу 41,713 нь эмэгтэй, 0.4 хувь буюу 341 нь хуулийн этгээд, үүний 38.7 хувь буюу 132 нь эмэгтэй удирдлагатай байна.

Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 54.2 хувь буюу 42,050 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 45.8 хувь буюу 35,507 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт (хот, орон нутгаар)




Нийт 176 ХЗХ-ны 29.0 хувь буюу 51 ХЗХ 20-100 гишүүнтэй, 53.4 хувь буюу 94 ХЗХ 101-500 гишүүнтэй, 10.2 хувь буюу 18 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 7.4 хувь буюу 13 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна. 1,001-ээс дээш гишүүнтэй ХЗХ-дын 46.2 хувь буюу 6 ХЗХ Улаанбаатар хотод, 53.8 хувь буюу 7 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 3: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд (интервалаар)	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	51	2,801	3.6%
101-500 гишүүнтэй	94	22,122	28.5%
501-1,000 гишүүнтэй	18	13,449	17.3%
1,001-ээс дээш гишүүнтэй	13	39,185	50.5%
<b>Нийт</b>	<b>176</b>	<b>77,557</b>	<b>100.0%</b>

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 13 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 50.5 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



## 1.4 Бодлого, зохицуулалтын орчин

### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

#### Хадгаламж, зээлийн хоршооны салбарт мөрдөгдөх эрх зүйн орчин

- Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 72 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.

#### Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын хэрэгжилт

- Хуульд заасны дагуу 2024 оны тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 174 ХЗХ-оос тайлант улирлын байдлаар 27.0 хувь буюу 47 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

#### Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

- 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 12 ХЗХ Монголбанкны СМА-д 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 3,431,232.59 мянган төгрөгийн 83 гүйлгээг мэдээлсэн бөгөөд сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

#### Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

- ХЗХ-д Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 176 ХЗХ-ны 61.4 хувь буюу 108 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Үүнээс 51.9 хувь буюу 56 ХЗХ нийслэлд, 48.1 хувь буюу 52 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

#### “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлвэл зохих 95 ХЗХ-оос 20 ХЗХ 21,630.0 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 2024 оны хэрэгжилтийг дүгнэж, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан.
- Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU)-оос “Өнөөгийн хэрэгцээ ба ирээдүйн боломж” нэрийн дор Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бүс нутгийн хэмжээнд хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, ирээдүйн чиг хандлага болон зохицуулалтын байгууллагуудын сайн туршлагыг судлах уулзалтад Хадгаламж, зээлийн хоршооны газрын төлөөлөл оролцож, Азийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын нийгэмлэг (ACCRA)-ийн дэд даргаар томилогдсон.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 176 ХЗХ-оос 2025 оны 1 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд 4 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан болно.

### 2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 4: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>176</b>	<b>100.0%</b>	<b>84</b>	<b>47.7%</b>	<b>92</b>	<b>52.3%</b>
<b>Нийт гишүүдийн тоо</b>	<b>77,557</b>	<b>100.0%</b>	<b>42,050</b>	<b>54.2%</b>	<b>35,507</b>	<b>45.8%</b>
Эрэгтэй	35,503	45.8%	18,288	51.5%	17,215	48.5%
Эмэгтэй	41,713	53.8%	23,505	56.3%	18,208	43.7%
Гишүүн хуулийн этгээд	341	0.4%	257	75.4%	84	24.6%
Эмэтэй удирдлагатай	132	38.7%	89	67.4%	43	32.6%
<b>Гишүүдийн насжилт</b>	<b>77,216</b>	<b>100.0%</b>	<b>41,793</b>	<b>54.1%</b>	<b>35,423</b>	<b>45.9%</b>
18-35 насны	19,110	24.7%	10,609	55.5%	8,501	44.5%
36-45 насны	23,940	31.0%	13,444	56.2%	10,496	43.8%
46-55 насны	18,574	24.1%	9,721	52.3%	8,853	47.7%
56-аас дээш	15,592	20.2%	8,019	51.4%	7,573	48.6%
<b>Гишүүдийн боловсрол</b>	<b>77,216</b>	<b>100.0%</b>	<b>41,793</b>	<b>54.1%</b>	<b>35,423</b>	<b>45.9%</b>
Дээд	34,253	44.4%	22,764	66.5%	11,489	33.5%
Тусгай дунд	12,945	16.8%	7,601	58.7%	5,344	41.3%
Бүрэн дунд	18,867	24.4%	9,349	49.6%	9,518	50.4%
Дунд	8,118	10.5%	1,822	22.4%	6,296	77.6%
Бага	3,033	3.9%	257	8.5%	2,776	91.5%
<b>Нийт ажилтнуудын тоо</b>	<b>626</b>	<b>100.0%</b>	<b>340</b>	<b>54.3%</b>	<b>286</b>	<b>45.7%</b>
Үүнээс: Эмэтэй	443	70.8%	237	53.5%	206	46.5%
<b>Санхүүгийн програмтай</b>	<b>96</b>	<b>54.5%</b>	<b>35</b>	<b>36.5%</b>	<b>61</b>	<b>63.5%</b>
<b>Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо</b>	<b>12</b>	<b>100.0%</b>	<b>10</b>	<b>83.3%</b>	<b>2</b>	<b>16.7%</b>
Гүйлгээний тоо	83	100.0%	75	90.4%	8	9.6%
Гүйлгээний дүн (мян.төг)	3,431,232.59	100.0%	3,316,954.89	96.7%	114,277.70	3.3%
<b>Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо</b>	<b>0.0</b>	<b>0.0%</b>	<b>0.0</b>	<b>0.0%</b>	<b>0.0</b>	<b>0.0%</b>
Сэжигтэй гүйлгээний тоо	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
Сэжигтэй гүйлгээний дүн (мян.төг)	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%

2025 оны 1 дүгээр улиралд нийт ХЗХ-дын 6.8 хувь буюу 12 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 3,431,232.59 мянган төгрөгийн 83 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 96.7 хувь буюу 3,316,954.89 мянган төгрөгийн 75 гүйлгээг Улаанбаатар хотын 10 ХЗХ, 3.3 хувь буюу 114,277.70 мянган төгрөг бүхий 8 гүйлгээг орон нутгийн 2 ХЗХ мэдээлсэн. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

Нийт ХЗХ-дын 54.5 хувь буюу 96 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Нийт 626 ажилтны 54.3 хувь буюу 340 нь Улаанбаатар хотын ХЗХ-нд, 45.7 хувь буюу 286 нь орон нутгийн ХЗХ-нд ажиллаж байна.


График 4: ХЗХ-ны гишүүдийн насжилт (хот, орон нутгаар)



Нийт гишүүдийн 44.4 хувь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 66.5 хувь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн 55.8 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.

График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин (хот, орон нутгаар)



Хүснэгт 5: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>176</b>	<b>100.0%</b>	<b>84</b>	<b>47.7%</b>	<b>92</b>	<b>52.3%</b>
<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	<b>281,241,845.53</b>	<b>100.0%</b>	<b>206,640,324.65</b>	<b>73.5%</b>	<b>74,601,520.88</b>	<b>26.5%</b>
<b>Нийт зээлдэгчийн тоо</b>	<b>30,059</b>	<b>100.0%</b>	<b>13,258</b>	<b>44.1%</b>	<b>16,801</b>	<b>55.9%</b>
Иргэн	29,937	99.6%	13,153	99.2%	16,784	99.9%
Эмэгтэй	17,201	57.5%	7,974	60.6%	9,227	55.0%
Хуулийн этгээд	122	0.4%	105	0.8%	17	0.1%
Эмэгтэй удирдлагатай	48	39.3%	39	37.1%	9	52.9%
<b>Зээлдэгчдийн насжилт</b>	<b>29,937</b>	<b>100.0%</b>	<b>13,153</b>	<b>43.9%</b>	<b>16,784</b>	<b>56.1%</b>
18-35 насны	7,925	26.5%	3,882	29.5%	4,043	24.1%
36-45 насны	8,804	29.4%	3,929	29.9%	4,875	29.0%
46-55 насны	7,530	25.2%	3,197	24.3%	4,333	25.8%
55-аас дээш	5,678	19.0%	2,145	16.3%	3,533	21.0%
<b>Зээлдэгчдийн боловсрол</b>	<b>29,937</b>	<b>100.0%</b>	<b>13,153</b>	<b>43.9%</b>	<b>16,784</b>	<b>56.1%</b>
Дээд	11,211	37.4%	6,148	46.7%	5,063	30.2%
Тусгай дунд	5,080	17.0%	2,357	17.9%	2,723	16.2%
Бүрэн дунд	7,129	23.8%	2,192	16.7%	4,937	29.4%
Дунд	5,118	17.1%	2,365	18.0%	2,753	16.4%
Бага	1,399	4.7%	91	0.7%	1,308	7.8%

Тайлант улиралд ХЗХ-д 30,059 зээлдэгчийн 281,241,845.53 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 44.1 хувь буюу 13,258 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 73.5 хувь буюу 206,640,324.65 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 55.9 хувь буюу 16,801 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 26.5 хувь буюу

74,601,520.88 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт зээлдэгчийн 99.6 хувь буюу 29,937 нь хувь хүн (57.5 хувь буюу 17,201 нь эмэгтэй), 0.4 хувь буюу 122 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 9,356.33 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 15,586.09 мянган төгрөг, орон нутагт 4,440.30 мянган төгрөг байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт		Үүнээс:		Орон нутаг	
	хадгаламж эзэмшигч Тоо	Хувь	Улаанбаатар хот Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>176</b>	<b>100.0%</b>	<b>84</b>	<b>47.7%</b>	<b>92</b>	<b>52.3%</b>
<b>Нийт хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>257,819,219.28</b>	<b>100.0%</b>	<b>197,295,384.90</b>	<b>76.5%</b>	<b>60,523,834.37</b>	<b>23.5%</b>
<b>Нийт хадгаламж эзэмшигчийн тоо</b>	<b>47,482</b>	<b>100.0%</b>	<b>25,515</b>	<b>53.7%</b>	<b>21,967</b>	<b>46.3%</b>
Иргэн	47,382	99.8%	25,463	99.8%	21,919	99.8%
<i>Эмэгтэй</i>	27,075	57.1%	13,836	54.3%	13,239	60.4%
Хуулийн этгээд	100	0.2%	52	0.2%	48	0.2%
<i>Эмэгтэй удирдлагатай</i>	43	43.0%	14	26.9%	29	60.4%
<b>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>6,691,201.22</b>	<b>2.6%</b>	<b>5,426,235.34</b>	<b>2.8%</b>	<b>1,264,965.89</b>	<b>2.1%</b>
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	6,928	14.6%	5,673	22.2%	1,255	5.7%
Иргэн	6,882	14.5%	5,636	22.1%	1,246	5.7%
Хуулийн этгээд	46	0.1%	37	0.1%	9	0.0%
<b>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>251,128,018.06</b>	<b>97.4%</b>	<b>191,869,149.57</b>	<b>97.2%</b>	<b>59,258,868.49</b>	<b>97.9%</b>
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	40,554	85.4%	19,842	77.8%	20,712	94.3%
Иргэн	40,500	85.3%	19,827	77.7%	20,673	94.1%
Хуулийн этгээд	54	0.1%	15	0.1%	39	0.2%
<b>Хадгаламж эзэмшигчдийн насжилт</b>	<b>47,382</b>	<b>100.0%</b>	<b>25,463</b>	<b>100.0%</b>	<b>21,919</b>	<b>100.0%</b>
18-35 насны	16,634	35.1%	11,146	43.8%	5,488	25.0%
36-45 насны	11,548	24.4%	5,314	20.9%	6,234	28.4%
46-55 насны	10,138	21.4%	4,807	18.9%	5,331	24.3%
56-аас дээш	9,062	19.1%	4,196	16.5%	4,866	22.2%
<b>Хадгаламж эзэмшигчдийн боловсрол</b>	<b>47,382</b>	<b>100.0%</b>	<b>25,463</b>	<b>100.0%</b>	<b>21,919</b>	<b>100.0%</b>
Дээд	20,130	42.5%	13,263	52.1%	6,867	31.3%
Тусгай дунд	6,516	13.8%	3,192	12.5%	3,324	15.2%
Бүрэн дунд	10,308	21.8%	4,212	16.5%	6,096	27.8%
Дунд	5,729	12.1%	1,952	7.7%	3,777	17.2%
Бага	4,699	9.9%	2,844	11.2%	1,855	8.5%

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 47,482 хадгаламж эзэмшигчийн 257,819,219.28 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 53.7 хувь буюу 25,515 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 76.5 хувь буюу 197,295,384.90 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 46.3 хувь буюу 21,967 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 23.5 хувь буюу 60,523,834.37 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 368,335,774.50 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувь буюу 52,160,443.35 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 14.6 хувийг хугацаагүй, 85.4 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 47,382 нь хувь хүн (57.1 хувь буюу 27,075 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 100 нь хуулийн этгээд (43.0 хувь буюу 43 нь эмэгтэй удирдлагатай) байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,429.83 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,732.53 мянган төгрөг, орон нутагт 2,755.22 мянган төгрөг байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 27.7 хувь буюу 60,976,431.64 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 17.2 хувь буюу 37,875,827.91 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 22.5 хувь буюу 3,923,668.70 мянган төгрөгөөр, нийт зарлага 14.8 хувь буюу 2,315,675.58 мянган

төгрөгөөр нэмэгдэж нийт цэвэр орлого 3,468,587.70 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ

үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 61.4 хувь буюу 108 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны I улирал	2025 оны I улирал	Өөрчлөлт Дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>316,175,331.15</b>	<b>368,335,774.50</b>		
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.5%	<b>52,160,443.35</b>	<b>16.5%</b>
<b>Нийт зээл</b>	<b>220,265,413.89</b>	<b>281,241,845.53</b>		
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.7%	<b>60,976,431.64</b>	<b>27.7%</b>
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>6,905,829.02</b>	<b>6,872,797.21</b>		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.1%	2.4%	<b>-33,031.81</b>	<b>-0.5%</b>
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.3%	-0.7%	-22.1%
			0.0%	0.0%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>219,943,391.37</b>	<b>257,819,219.28</b>		
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	1.0%	<b>37,875,827.91</b>	<b>17.2%</b>
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>28,327,858.14</b>	<b>29,692,865.74</b>		
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>42,744,977.06</b>	<b>47,887,288.30</b>	<b>1,365,007.59</b>	<b>4.8%</b>
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>4,231,964.49</b>	<b>4,302,230.72</b>	<b>5,142,311.24</b>	<b>12.0%</b>
Нийт орлого	17,466,195.07	21,389,863.76	<b>70,266.23</b>	<b>1.7%</b>
Нийт зарлага	15,605,600.48	17,921,276.06	3,923,668.70	22.5%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>1,860,594.59</b>	<b>3,468,587.70</b>	2,315,675.58	14.8%
			<b>1,607,993.11</b>	<b>86.4%</b>

## 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 84 ХЗХ-ны нийт хөрөнгө 280,438,065.17 мянган төгрөг нь зах зээлийн 76.1 хувь, нийт зээл 206,640,324.65 мянган төгрөг нь зах зээлийн 73.5 хувь, нийт хадгаламж 197,295,284.90 мянган төгрөг нь зах зээлийн 76.5 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.4 хувь буюу 323,665.41 мянган төгрөгөөр буурч 5,687,328.71 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 2.8 хувийг эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 20.1 хувь буюу

2,614,095.02 мянган төгрөгөөр, нийт зарлага 10.5 хувь буюу 1,234,539.48 мянган төгрөгөөр, цэвэр орлого 1.1 дахин буюу 1,379,555.55 мянган төгрөгөөр өсөж 2,603,519.42 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 66.7 хувь буюу 56 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны I улирал	2025 оны I улирал	Өөрчлөлт Дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>246,158,382.62</b>	<b>280,438,065.17</b>		
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	77.9%	76.1%	<b>34,279,682.54</b>	<b>13.9%</b>
<b>Нийт зээл</b>	<b>163,230,392.59</b>	<b>206,640,324.65</b>		
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	74.1%	73.5%	<b>43,409,932.06</b>	<b>26.6%</b>
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>6,010,994.12</b>	<b>5,687,328.71</b>		
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	87.0%	82.8%	<b>-323,665.41</b>	<b>-5.4%</b>
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.7%	2.8%	-4.3%	-4.9%
			-0.9%	-25.3%

<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>173,144,387.91</b>	<b>197,295,384.90</b>	<b>24,150,996.99</b>	<b>13.9%</b>
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	78.7%	76.5%	-2.2%	-2.8%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>20,519,899.29</b>	<b>21,013,115.75</b>	<b>493,216.45</b>	<b>2.4%</b>
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	72.4%	70.8%	-1.7%	-2.3%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>32,204,646.74</b>	<b>35,169,115.53</b>	<b>2,964,468.79</b>	<b>9.2%</b>
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	75.3%	73.4%	-1.9%	-2.5%
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>3,848,765.23</b>	<b>4,181,395.83</b>	<b>332,630.60</b>	<b>8.6%</b>
Нийт орлого	13,030,601.10	15,644,696.13	2,614,095.02	20.1%
Нийт зарлага	11,806,637.23	13,041,176.71	1,234,539.48	10.5%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>1,223,963.87</b>	<b>2,603,519.42</b>	<b>1,379,555.55</b>	<b>112.7%</b>

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 92 ХЗХ-ны нийт хөрөнгө 87,897,709.33 мянган төгрөг нь зах зээлийн 23.9 хувь, нийт зээлийн үлдэгдэл 74,601,520.88 мянган төгрөг нь зах зээлийн 26.5 хувь, нийт хадгаламж 60,523,834.37 мянган төгрөг нь зах зээлийн 23.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 29.5 хувь буюу 1,309,573.67 мянган төгрөгөөр, нийт зарлага 28.5 хувь буюу 1,081,136.11 мянган төгрөгөөр тус тус өсөж, нийт цэвэр орлого

865,068.28 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 56.5 хувь буюу 52 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 9: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны I	2025 оны I	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>70,016,948.52</b>	<b>87,897,709.33</b>	<b>17,880,760.81</b>	<b>25.5%</b>
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	22.1%	23.9%	1.7%	7.8%
<b>Нийт зээл</b>	<b>57,035,021.30</b>	<b>74,601,520.88</b>	<b>17,566,499.58</b>	<b>30.8%</b>
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	25.9%	26.5%	0.6%	2.4%
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>894,834.90</b>	<b>1,185,468.50</b>	<b>290,633.61</b>	<b>32.5%</b>
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	13.0%	17.2%	4.3%	33.1%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.5%	0.6%	0.0%	4.6%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>46,799,003.45</b>	<b>60,523,834.37</b>	<b>13,724,830.92</b>	<b>29.3%</b>
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	21.3%	23.5%	2.2%	10.3%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>7,807,958.85</b>	<b>8,679,749.99</b>	<b>871,791.14</b>	<b>11.2%</b>
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	27.6%	29.2%	1.7%	6.1%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>10,540,330.32</b>	<b>12,718,172.78</b>	<b>2,177,842.46</b>	<b>20.7%</b>
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	24.7%	26.6%	1.9%	7.7%
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>383,199.26</b>	<b>120,834.89</b>	<b>-262,364.37</b>	<b>-68.5%</b>
Нийт орлого	4,435,593.96	5,745,167.64	1,309,573.67	29.5%
Нийт зарлага	3,798,963.25	4,880,099.35	1,081,136.11	28.5%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>636,630.71</b>	<b>865,068.28</b>	<b>228,437.57</b>	<b>35.9%</b>

### 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан. Журам шинэчлэн баталсантай холбоотойгоор хадгаламж болон зээлийг хүлээн зөвшөөрөх хэмжилтийн сууриуд, үнэ цэнийн өсөлт бууралт, хүүг хуримтлуулан

тооцох, шимтгэл хураамжийг хойшлуулан бүртгэх, тэнцлээс хасах, тэнцлээс хассан зээлийн орлогыг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийн санг СТОУС-ын дагуу ангилах, бүртгэлийн арга хандлагыг нарийвчлан зохицуулж, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар, дансны жагсаалтыг шинээр боловсруулж, ерөнхий данс, үндсэн дансанд өөрчлөлт орсон тул дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2024 оны I улирал		ХӨРӨНГӨ	2025 оны I улирал	
	Дүн	Хувь		Дүн	Хувь
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>312,000,095.31</b>	<b>98.7%</b>	<b>САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>356,085,134.00</b>	<b>96.7%</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	<b>71,691,535.26</b>	<b>22.7%</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>61,199,041.62</b>	<b>16.6%</b>
Бэлэн мөнгө	3,488,466.54	1.1%	Бэлэн мөнгө	3,689,576.13	1.0%
Банкинд байршуулсан харилцах	11,890,959.70	3.8%	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	13,392,316.16	3.6%
Банкинд байршуулсан хадгаламж	56,312,109.01	12.6%	Банканд байршуулсан хадгаламж	42,717,239.44	11.6%
			Замд яваа мөнгө	5,708.16	
			Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-
			Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,394,201.72	0.4%
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	<b>820,000.00</b>	<b>0.3%</b>			
Арилжааны үнэт цаас	820,000.00	0.3%			
<b>Зээл (цэвэр)</b>	<b>214,829,871.37</b>	<b>67.9%</b>	<b>Зээл (цэвэр)</b>	<b>289,188,834.93</b>	<b>78.5%</b>
Нийт зээл	220,265,413.89	69.7%	Нийт зээл	281,241,845.53	76.4%
Хэвийн зээл	205,061,934.19	64.9%	Хэвийн зээл	260,087,790.38	70.6%
Хугацаа хэтэрсэн зээл	8,297,650.68	2.6%	Хугацаа хэтэрсэн зээл	14,281,257.93	3.9%
Чанаргүй зээл	6,905,829.02	2.2%	Чанаргүй зээл	6,872,797.21	1.9%
			Зээлийн хойшлогдсон орлого	-	-
			Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	13,180,645.56	3.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	5,435,542.52	1.7%	(Зээлийн эрсдэлийн сан)	5,233,656.16	1.4%
			Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	-	-
<b>Авлага</b>	<b>19,627,900.43</b>	<b>6.2%</b>			
Байгууллага, хүмүүсээс авах авлага	7,577,478.76	2.4%			
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	12,050,421.67	3.8%			
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	<b>4,100,859.56</b>	<b>1.3%</b>	<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>	<b>5,697,257.45</b>	<b>1.5%</b>
Татварын авлага	335,406.01	0.1%	Дансны авлага (цэвэр)	945,741.32	0.3%
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	2,784,333.41	0.9%	Дансны авлага	1,135,526.96	0.3%
Дараа тайлангийн тооцоо	581,950.73	0.2%	Хувь хүнээс авах авлага	330,939.99	0.1%
Дугагдал, шамшигдал	125.66	0.0%	Хуулийн этгээдээс авах авлага (Авлагын эрсдэлийн сан)	804,586.97	0.2%
Хангамжийн зүйлс	399,043.75	0.1%	Холбоотой талаас авах авлага	189,785.64	0.1%
Салбар хоорондын авлага	-	-	Ажиллагчдаас авах авлага	2,240,004.82	0.6%
			Салбар хоорондын тооцоо	15,298.01	0.0%
				-	-

			Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө (цэврээр)	2,483,500.02	0.7%
			Бусад	12,713.27	0.0%
<b>Өмчлөх бусад хөрөнгө (цэвр)</b>	<b>929,928.69</b>	<b>0.3%</b>			
Өмчлөх бусад хөрөнгө	972,518.88	0.3%			
(Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)	42,590.19	0.0%			
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b>4,175,235.84</b>	<b>1.3%</b>	<b>САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b>12,250,640.50</b>	<b>3.3%</b>
Үндсэн хөрөнгө (цэвр)	3,995,636.12	1.3%	Татварын авлага	340,013.75	0.1%
Биет бус хөрөнгө	164,097.03	0.1%	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	1,395.13	0.0%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	15,502.69	0.0%	Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,043,995.41	0.8%
			Бараа материал	436,445.66	0.1%
			Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	1,054,925.44	0.3%
			Бусад санхүүгийн бус хөрөнгө	160,150.19	0.0%
			Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (цэврээр)	-	0.0%
			Үндсэн хөрөнгө (цэврээр)	4,686,114.04	1.3%
			Биет бус хөрөнгө (цэврээр)	2,527,600.87	0.7%
<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>316,175,331.15</b>	<b>100.0%</b>	<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>368,335,774.50</b>	<b>100.0%</b>

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 368,335,774.50 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувь буюу 52,160,443.35 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.7 хувийг санхүүгийн хөрөнгө, 3.3 хувийг санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 16.6 хувийг, цэвр зээл 78.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.7 хувь буюу 60,976,413.64 мянган төгрөгөөр өсөж 281,241,845.53 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,233,656.16 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна. Харин чанаргүй зээл 0.5 хувь буюу

33,031.81 мянган төгрөгөөр буурч 6,872,797.21 мянган төгрөг болсон бол хугацаа хэтэрсэн зээл 72.1 хувь буюу 5,983,607.25 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

График 6: Нийт хөрөнгийн бүтэц



ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлт 2023 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар буурсан боловч сүүлийн 5 жилээр харьцуулахад дунджаар 11.2 хувиар өссөн. Нийт зээлийн хэмжээ дунджаар 10.7 хувиар өссөн бол чанаргүй зээлийн хэмжээ дунджаар 1.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгө, зээлийн багцын өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)


	2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I	Дүрслэл
ХЗХ-ны тоо	249	205	191	184	176	
Нийт хөрөнгө	278.9	291.3	274.55	316.2	368.3	
Нийт зээл	192.1	219.3	212.5	220.3	281.2	
Чанаргүй зээл	7.0	7.0	7.5	6.9	6.9	

### 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 6 ХЗХ-ны нийт хөрөнгө 227,080,147.86 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 61.7 хувийг, гишүүдийн тоо 23,141 байгаа нь нийт гишүүдийн 29.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	6	227,080,147.86	61.7%	23,141	29.8%
2	1,000,000.0 -10,000,000.0	35	105,951,640.95	28.8%	30,160	38.9%
3	500,000.0-1,000,000.0	23	16,384,092.40	4.4%	9,094	11.7%
4	100,000.0-500,000.0	68	16,313,815.64	4.4%	11,997	15.5%
5	50,000.0-100,000.0	28	2,183,314.42	0.6%	2,289	3.0%
6	10,000.0-50,000.0	14	413,329.94	0.1%	803	1.0%
7	10,000.0 хүртэл	2	9,433.29	0.0%	73	0.1%
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>368,335,774.50</b>	<b>100.0%</b>	<b>77,557</b>	<b>100.0%</b>



### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 281,241,845.53 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 76.4 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 289,188,834.93 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 78.5 хувийг тус тус эзэлж байна. Нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэгдсэнээр цэвэр зээлийн үндсэн дансанд хамаарах бусад нэрийн дансуудыг нэмэгдсэнээр тооцоолсон болно.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.25 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.05 хувь байгаа бол Улаанбаатар хотын ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.11 хувь, орон нутгийн ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.64 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 35 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 88.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	35	247,907,494.79	88.1%
2	500,000.0-1,000,000.0	22	15,475,869.70	5.5%
3	100,000.0-500,000.0	66	15,263,225.55	5.4%
4	50,000.0-100,000.0	27	1,971,550.08	0.7%
5	10,000.0-50,000.0	19	612,167.74	0.2%
6	10,000.0 хүртэл	4	11,537.67	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	3	-	-
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>281,241,845.53</b>	<b>100%</b>

### 3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 14: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
